

ХӨГЖЛИЙН ТУХАЙ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГИЙН УТГА АГУУЛГА

Доктор И.Бүрэн-Өлзий

Түлхүүр үг: хөгжил, хөдөлгөөн, түгээмэл холбоо, өөрчлөлт, жам ёс,

Ертөнц нэгдэлтэй гэдэг нь юуны өмнө түүнд үйлчилж буй хуулиар илэрдэг. Тэрхүү хууль зүй тогтлыг танин мэдэж байж ертөнцийг танин мэднэ. Диалектик сургаалын хүрээнд ертөнцийн тэрхүү түгээмэл, нэгдмэл зүй тогтлын мөн чанарыг судлан авч үздэг. Үүнд Ертөнц бол материаллаг болон оюун санааны ертөнцийн нэгдэл байдлаар оршиж байдаг бөгөөд ертөнц дээрх бүхий л үзэгдэл, үйл явц нь түгээмэл холбоотой, ингэхдээ тэдгээр нь харьцангуй биеэ даасан бүхэллэг байдлаар оршдог. Ертөнцийн юмсын хамгийн түгээмэл зүй тогтол гэвэл хөдөлгөөн, өөрчлөлт, хувьсал хөгжил. Тэрхүү хөдөлгөөн, хөгжлийн уг сурвалж нь дотоод дахь зөрчил. Ийм болохоор ертөнцийн юмс үзэгдэл объектив бодитойгоор орших төдийгүй байнгын хөгжил хөдөлгөөнд оршдог гэсэн үг.

Диалектикийн үүднээс ертөнцийн аливаа юмс нь түгээмэл холбоонд орших төдийгүй хөгжиж өөрчлөгдөж байдаг жам ёстой хэмээн үздэг. Хөгжил дотооддоо хувьсамтгай, тогтвортой нь хоёр талт харилцааг агуулж байдаг бөгөөд, тогтвортой шинж нь билиг буюу инь, хувьсамтгай шинж нь арга буюу ян болдог. Төв үзлийн үүднээс хувьсамтгай буюу тогтвортойг синтезлэж, шүтэн барилдуулж авч үздэг бөгөөд энэ нь юмс бүрт байх зайлшгүй түгээмэл шинж хэмээнэ.

Ардын зүйр цэцэн үгийн дотор ертөнцийн хөгжил өөрчлөлтийн уг сурвалж, түүний хөдөлгөгч, хүч шалтгааны тухай тэр нь түгээмэл шинжтэй болох тухай үзэл санаа элбэг агуулагдаж байдаг. Жишээлбэл:

Хоёр тал нийлж

Нэг бүтэн болох

Хоёр хүн нийлж

Нэг амь болох

А.Сайнтай муу тэмцэж

Сайхантай муухай тэмцэх

Б.Сайнтай муу мөчөөрхөж

Сайхантай муухай мөчөөрхөх /29-5717/

Авах хүн бөхийдөг

Өгөх хүн гэдийдэг /28-102/ гэх мэт

Эдгээр зүйр цэцэн үгэнд арга билиг, нэгдэл тэмцэл бол аливаа юмсын дотоодод орших зөрчилт талууд бөгөөд энэ нь түгээмэл шинжтэй болохыг өгүүлж буй хэрэг юм. Үүнд; "их болон бага", "сайн болон муу", "сайхан болон муухай", "авах болон өгөх", "бөхийх болон гэдийх" зэрэг нь аливаа бүтэн зүйлийн хоёр тал төдийгүй, тэдгээр нь харилцан зөрчилдөхийн хэрээр харилцан холбогдож, бие биеэ үгүйсгэхийн хэрээр нөхцөлдүүлж зэрэгцэн оршиж байдгийг илэрхийлжээ. Угтаа зөрчил бол юмсын оршихуйн уг чанар юм. Жишээлбэл;

Үхэх төрөх хоёр

Өдөр шөнө үргэлжлэх

Үгүйрэх баяжих хоёр

Өвөл хавар ялгарах /29-7785/

Үхэж байвч үрждэг

Үгүйрч байвч баяждаг /29-7763/ гэх мэтээр өгүүлж буй эдгээр зүйр цэцэн үгэнд “үхэх хийгээд төрөх” нь “өдөр, шөнө”-ийн аль нэгэнд үргэлжлэдэг; учир нь өдөр шөнө хоёр ээлжлэн орших нь сав ертөнцийн жам агаад “өдөр үгүй шөнө, шөнө үгүй өдөр гэж хэзээ ч үгүй” энэ орчлонгийн дотор оршигч хүмүүнд “төрөх, үхэх нь” хэзээд зайлшгүй шинжтэй болохоор өдөр шөнийн аль нэгэнд л тохиох нь зүй ёсных аж. Түүнчлэн “үгүйрэх хийгээд баяжих” нь “өвөл хавар”-ын аль нэгэнд “ялгардаг” нь шим ертөнцөд амьдрагч хүмүүний сав ертөнтэйгээ хэрхэн зохицон амьдрах түүний хууль зүй тогтлыг танин мэдэхээс хамааралтай гэдгийг өгүүлж буй хэрэг юм. Учир нь үгүйрэх болон баяжих нь өвөл, хаврын хатуу, хахирган улирлын жам ёсыг хэрхэн ухаарч, зун, намрын цагт бэлтгэл ажлаа хэрхэн хангах ажилсаг, хичээнгүй үйлдэл үйл ажиллагаанаас шууд хамааралтай болохыг, нөгөө талаар энэ нь санамсаргүй шинжтэй олон үйлдлээр илэрдэг болохыг өгүүлжээ.

В.Инжинашийн “Хөх судар” романд өгүүлэхдээ: “Орчлон хэмээгч нийтээр арга билгээс бүтжээ. Арга билгийн хоёр амьсгал бүхий газарт хүмүүн амьтан төрж үүсмой. Нэгэнт хүмүүн төрөлхтний биеийг олж төрвөөс эрх биш мэдэл оюун амой”¹ гэсэн буй. Ийнхүү сав, шим ертөнцийн аливаа юмс цөм эсрэг тэсрэг талуудын харилцаан дунд зохих нөхцлийн дотор бие биенээ үгүйсгэхийн хэрээр харилцан холбогдож орших ажээ. Гүн ухаантан Дэмчигдоржийн айлдсанаар “Арга билгийн ёсон үгүй нь хаана ч үгүй аж”. Тийм болохоор тэрхүү зүй тогтлын дагуу үзэгдэл юмсын түгээмэл шинжтэй мөн чанарыг танин мэдэх нь сэтгэлгээний арга зүйн зөв баримтлал болох бөгөөд ертөнцийн оршихуйн уг чанарыг зөвөөр ойлгох үндэслэл болж өгөх юм.

Объектив ертөнцийн юмс үзэгдэл нь оршихуй эс оршихуйн харилцан шүтэлцээтэйгээс гадна түгээмэл хэлхээ холбоонд хөгжиж өөрчлөгдөж байдаг жам ёстой билээ. Тодруулбал аливаа оршигч бүхэн байнгын хөгжил хөдөлгөөн дунд тасралтгүй хувирч өөрчлөгдөж, үүсэж устаж байдаг.

Дорно дахины арга билгийн сэтгэлгээний үүднээс зөрчилт шүтэн барилдлага нь хөгжил, хөдөлгөөний уг сурвалж хэмээдэг. Чухамдаа ертөнцөд өөрчлөлт хувиралтгүй зүйл гэж нэгээхэн ч үгүй. Арга билгийн зөрчилт талууд нь харилцан үйлдэлд орж юмсын өөрчлөгдөн хувирах нөхцлийг бүрдүүлдэг аж. Тухайлбал;

Өнгө өнгөөрөө байдаггүй

Өвс хөхөөрөө байдаггүй /28-5153/

Цаг, нэгээрээ байдаггүй

Цагаан, өнгөөрөө байдаггүй /25-10507/ нь орчлонгийн түгээмэл жам ёс болохыг илэрхийлжээ.

Юмсын хөгжлийн дотоод дахь эсрэг талууд зохих нөхцлийн дор нэгээс нөгөөд шилждэг тухай

Хонины мах хуучирвал хор болж

Үхрийн мах хуршвал эм болдог /3-тал-18/

Залилах гээд замаан алдана

¹. Инжинаши В.Хөх судар I, II, III дэвтэр. ӨМАХХ., 1959. 20 дах тал

Зандрах гээд хүндээн алдана /28-2709/

Хорт санаа биендээн

Хуурмаг явдал эзэндээн /8-тал-39/ гэх мэтээр юмсын улиран шилжих нөхцөл байдлыг ихээхэн анхаарах хэрэгтэй гэсэн санааг агуулж байна.

Хөгжлийн ахиц шат, механизм, улиран дэвших зүй тогтлын тухай өгүүлэхдээ: Өөдлөх зам – уруудах замтай

Уруудсан хүн - өөдлөх замтай /25-8361/

А.Оргих нь ихэдвэл ширгэх нь их

Орох нь ихэдвэл гарах нь их

Б.Онгирах нь ихэдвэл

Унах нь их /28-4854/

Залуу нас зэрэглээ шиг жирэлздэг

Өвгөн нас мэлхий шиг мөлхдөг /25-7234/

Залуу хэдий сайн ч бол хөгширдөг

Аранзал хэдий өнгөтэй ч бол ганддаг /25-7249/ гэхмэт.

Хөгжлийг үзэх гурвалын үзэл нь өрнө, дорны /Дж.Вико, О.Конт, Шпенглер, Гегель, Бердяев/ сэтгэлгээний хүрээнд боловсрон хөгжиж ирсэн бөгөөд үзэгдэл юмсын бие биенээ, үгүйсгэх, нөхцөлдүүлэхийн хэрээр харилцан улиран дэвших жам хуулийн илэрхийлэл юм. Тухайлбал; Эртний Хятадын гүн ухаанд нийгмийн хөгжил нь "Датун-Сяокан-Датун" (датун-эв нэгдэл, найрамдал, нөхөрлөл, харилцан бие биедээ тавих халамжийн шат, Сяоканы үе бол эвдрэлцэл, дайсагналцлын үе), гэсэн гурван шатаар, Гегель хөгжлийн гурвал шатыг "тезис – антитезис - синтез" хэмээн томъёолсон байдаг.

Чухамдаа аливаа юмсын хөгжил нь зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд харилцан байраа солих замаар тэнцвэрийн хуулийн дагуу урагш ахин дэвших уруудан буурах зүй тогтолтой. Үүнийг улиран дэвших зүй тогтол гэнэ. Хөгжлийн нэг шатанд зөрчлийг бий болгогч талуудын нэг нь дэвших, голлох, тодорхойлох, давамгайлах, нөгөө нь улирах, дагалдах үүрэгтэй байх бөгөөд дараагийн шатанд эхнийх нь улирах, хоёр дахь нь дэвших замд ордог.

Дээрх зүйр цэцэн үгүүдэд хөгжлийн улиран дэвших зүй тогтолт шинж байдлыг "өөдлөх уруудах өөдлөх" нь хөгжлийн жам ёс бөгөөд аливаа юмсад "өсөх, өрнөх, дэвших, дээшлэх цаг байх төдийгүй бас уруудах, буурах, унах, мөхөх" үйл явц ч дагалдах агаад хэдий чинээ өгсөнө, төдий чинээ урууддаг, хэдий чинээ уруудана, төдий чинээ өгсөх жам ёсыг "оргих нь ихэдвэл ширгэх нь их, орох нь ихэдвэл гарах нь их"- байх учир ёсоор зүйрлэн гаргажээ. Хөгжлийн энэ жам хуулийг зөв ухаарч ойлгох нь ихээхэн чухал бөгөөд өөрчлөлт хувиралтгүй зүйл нэгэнт үгүй болохоор цаг хугацааг сайн тооцож насны залууд сурч, бүтээж эс чадваас "залуу нас" нэг л мэдэхэд зэрэглээ мэт хурдан өнгөрч "өвгөн нас" хаяанд ирэх нь зайлшгүйг сургамжтайгаар гаргаж өгчээ.

Юмс үзэгдлийн хөгжил нь улиран шилжих үйл явцдаа ахин дэвших, урагш хөгжих, шинэ нь хуучнаа халах буюу өвлөн уламжлах шинж чанартайг ардын зүйр цэцэн үгэнд тодорхой илэрхийлсэн нь цөөнгүй бий. Тухайлбал: Хөгжлийн залгамж чанар, өвлөн уламжлагдах шинж чанарыг:

Юм нэгээрээ өнгөрдөггүй

Хүн ганцаараа дуусдаггүй /25-10990/

Үр өсөж эр болох

Үрээ өсөж хүлэг болох /28-7636/

Үрээ даага өсөж унаа залгах

Үр хүүхэд бойжиж өрх залгах /28-7669/ гэх мэтээр шинэ нь хуучнаа давамгайлах байдлаар хөгждөгийг зааж өгчээ.

Үүсч бий болж буй юмс нь эхэндээ хүчин буурай, хөгжил дорой байхын эрхээр хуучиндаа давагдаж ялагдаж байдаг боловч, аажимдаа түүнийг үгүйсгэж давамгайлах шинж чанартай болдог тухай.

Идсэн эрүү хувхайрч

Идүүлсэн /идэгдсэн/ дов ногоордог /28-3212/

Урьд гарсан чихнээс

Хойно ургасан эвэр урт/29-6967/ гэх мэтийн зүйр цэцэн үгүүдэд илэрхийлж байна.

Нөгөө талаар хөгжлийн жам хуулийн зайлшгүй шинж чанарыг;

Өсөх тавилантай

Өтлөх жамтай /28-5390/

Өтлөө гэж өтлөдөггүй

Өнгөт ертөнцийн жамаар болох /28-5409/

Усны үер өнгөрвөл

Эргэж урсдаггүй

Залуу нас өнгөрвөл

Эргэж ирдэггүй /28-7044/

Үерийн ус ирвэл

Үүд хоймор ялгаагүй

Үхлийн цаг ирвэл

Хөгшин залуу ялгаагүй /28-7442/ хэмээн цаг хугацааны эргэлт буцалтгүйн уг ёсыг танин мэдэж үйлдэл үйл ажиллагаандаа анхаарахын учир ёсыг өгүүлсэн нь ч цөөнгүй байна.

Ийнхүү хөгжлийн тухай сургаал нь монголчуудын үзэл сэтгэлгээнд түгээмлээр тусгагдаж ирсэн бөгөөд тэдний ертөнцийг үзэх үзлийн арга зүйн нэгэн чухал баримтлалыг ардын зүйр цэцэн үгийн агуулгаас харахад илэрхий байна.

Ном зүй

- Монгол зүйр цэцэн үг. Тэргүүн дэвтэр.УБ.,2002.

- Инжинаш,В,Хөх судар,ӨАММХ, 1959в